

English*Connect* 2

FOR LEARNERS

LESSONS 1–25

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс
хэвлэв

Юта муж, Солт Лэйк Сити

© 2017 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Хувилбар: 2/17

EnglishConnect 2 for Learners-ын орчуулга

Mongolian

14703 363

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

ENGLISH-CONNECT 1

Анхан шатны дундаас - Анхан шатны ахисан түвшин

Зорилго: Цалинтай ажлын боломжууд болон EnglishConnect 2-ын бэлтгэл.

Суралцагчийн товч намтар: Төрөлх хэлээрээ бичиг үсэгт тайлагдсан, латин цагаан толгой болон авиа зүйг мэддэг байх.

Сургалтын хөтөлбөр: Унших, бичих дадлага хязгаарлагдмал ба англи хэлний анхан шатны ярианы чадвар эзэмшинэ.

ENGLISH-CONNECT 2

Дунд шатны доод түвшнээс - Дунд шатны дунд түвшин

Зорилго: Цалинтай ажлын боломжууд болон EnglishConnect 3-ын бэлтгэл.

Суралцагчийн товч намтар: Хамгийн багадаа дунд шатны доод түвшинд байх ёстой.

Сургалтын хөтөлбөр: Унших, бичих дадлага хязгаарлагдмал ба англи хэлний анхан шатны ярианы чадвар эзэмшинэ.

ENGLISH-CONNECT 3

Дунд шатны доод түвшнээс - Дунд шатны ахисан түвшин

Зорилго: Академик англи хэлний чадварууд болон оффисын ажлын боломжууд.

Суралцагчийн товч намтар: Хамгийн багадаа дунд шатны доод түвшинд байх ёстой.

Сургалтын хөтөлбөр: Англиар унших, бичих, сонсох, ярих академик түвшний бэлтгэл.

Энэ бүтээгдэхүүнийг одоо сайжруулж байгаа.

PATHWAY-CONNECT

Дунд шатны ахисан түвшнээс - Ахисан шатны доод түвшин

Зорилго: Их сургуульд ороход бэлэн ур чадварууд болон оффисын ажлын боломжууд.

Суралцагчийн товч намтар: Хамгийн багадаа дунд шатны ахисан түвшинд байх ёстой.

Сургалтын хөтөлбөр: Амьдрах ур чадвар, бичгийн болон математикийн чиглэлээр их, дээд сургуулийн түвшний сургалтад элсэж орно.

EnglishConnect 2 хөтөлбөрт тавтай морилно уу. Англиар ярьдаг байх нь таны амьдралд агуу адислалуудыг авчрах болно. Англи хэлний ур чадварууд нь илүү сайн ажлын байр луу хөтөлж, боловсрол эзэмшихэд тань тусалж, найз нөхөд, танилын хүрээгээ тэлэх болон бусад олон арга замаар танд тусалж чадна.

Дээрх бүдүүвч зурагт үзүүлсэнчлэн, энэ курс нь EnglishConnect нэртэй томоохон бүтээгдэхүүний нэг хэсэг юм. Дээрх бүдүүвч зургийг хараад, EnglishConnect-ийн санал болгож буй зүйлийг үзээрэй. Мөн энэ курс ойрын ирээдүйд танд хэрхэн тусалж болох талаар бодож үзэх цаг гарга.

Энэхүү курсийн зорилго нь Англи хэлний ярианы анхан шатны чадваруудаа хөгжүүлэхэд тань туслахад чиглэсэн байдаг тул EnglishConnect 2-ын үйл ажиллагаанууд нь үгсийн сан, сонсгол, ярианы дадлага дээр төвлөрдөг.

Энэхүү курс нь таныг хичээлээс гадуур давтах, дадлага хийх, суралцахын тулд танаас интернэт болон бусад технологи (аппликэйшнууд гэх мэт) руу нэвтрэн орох боломжтой байхыг шаарддаг. Аливаа ур чадварыг хөгжүүлдэгтэй адил байнга хийх дадлага, зарцуулах цаг хугацаа нь англи хэлээр ярих чадвараа хөгжүүлэхэд тань тусална. Тиймээс анги дотроо болон гадуур аль болох их дадлага хий. Тогтмол чармайж, хичээнгүй байж, зугаатай байдлаар суралц.

Та хичээлийн зорилгодоо хүрэхийн тулд бусадтай хамтран ажиллахдаа золиос, ажил хөдөлмөр, бие даасан байдал, хайраас ирэх адислалуудыг мэдрэх болно. Таны эерэг хандлага, бэлтгэл, хүсэл зориг өөрийн тань болон эргэн тойрныхны тань амьдралыг сайжруулна.

Хамгийн сайн сайхныг хүсье!

АГУУЛГА

Танилцуулга	vi
Lesson 1: Introductory Lesson	2
Lesson 2: Introductions	4
Lesson 3: Interests	6
Lesson 4: Family and Friends	8
Lesson 5: Family and Friends	10
Lesson 6: Feelings and Emotions	12
Lesson 7: Interests	14
Lesson 8: At Home	16
Lesson 9: At Home	18
Lesson 10: Daily Routines	20
Lesson 11: Daily and Weekly Routines	22
Lesson 12: Past Experiences, Part 1	24
Lesson 13: Past Experiences, Part 2	26
Lesson 14: Money, Shopping for Food	28
Lesson 15: Money and Shopping	30
Lesson 16: In the Community	32
Lesson 17: In the Community	34
Lesson 18: Holidays	36
Lesson 19: Going on Vacation	38
Lesson 20: Health and Sickness	40
Lesson 21: Health and Sickness	42
Lesson 22: Special Occasions	44
Lesson 23: Special Occasions	46
Lesson 24: Goals and Dreams	48
Lesson 25: Review	50
EnglishConnect 2 Grammar Principles	52
EnglishConnect 2 Lesson and Homework Vocabulary	57

ТАНИЛЦУУЛГА: ENGLISHCONNECT 2

ЯАГААД ТА АНГЛИ ХЭЛ СУРЧ БАЙГАА ВЭ?

EnglishConnect-д тавтай морилно уу. Англи хэл сурах нь боловсрол эзэмших боломжуудыг олж авах, илүү сайн ажилтай болох, найз нөхдийн хүрээгээ тэлэх зэрэгт тань туслах болно. EnglishConnect хичээлүүд нь танд үг хэлэх, харилцан ярих чадвар олж авахад тусална. Энэ хичээлүүд нь англи хэлээр уншиж, бичихийг заахгүй. Та англиар унших, бичих чадварыг EnglishConnect курсийн бусад хичээлээр сурч болно.

Эхлэхийн өмнө та **яагаад** англи хэл сурах болсноо тодорхойлоод, шалтгаанаа бичиж ав. Шантрах үедээ та бичсэн зүйлсээ хар. Яагаад англи хэл сурч байгаагаа санаж байх нь тууштай байхад тань тусална.

Миний англи хэл сурах болсон шалтгаан бол _____

Англи хэлийг амжилттай сурахын тулд танд дараах зүйлс хамгийн чухал. Үүнд:

- Англи хэлийг өдөр бүр хэрэглэ. Өдөр бүр бага багаар дадлага хийх нь цөөн өдөр их дадлага хийхээс дээр.
- Долоо хоног бүрийн англи хэлний зорилгуудаа тодорхойл. Эдгээр нь “Би шинээр 20 үг цээжилнэ” гэх мэт тодорхой байх хэрэгтэй. Зорилгуудаа бич мөн ахицаа тэмдэглэ.

Мөн хэзээ, хаана, юуг, хэрхэн судлахаа шийдэх нь тун чухал.

ТА ЮУ СУДЛАХ ВЭ?

EnglishConnect Суралцагчийн гарын авлага

Энэ ном нь EnglishConnect курсийн турш танд туслах болно. Энэ нь хичээл бүрд зориулсан дасгал ажил болон бусад эх сурвалжийг агуулдаг. Гэвч та англи хэлийг ганц энэ номоос сурч чадахгүй. Ийм учраас та долоо хоног бүр хичээлдээ суух нь чухал.

- Долоо хоног бүр энэ номыг ангид авчир.
- Номон дээр тэмдэглэл хийж, дасгалуудаа гүйцээ.
- Одоогийн үзэж буй хичээлийн үгсийг давтаад, үгсийн сангийн хавсралт дээрх гэрийн даалгаврын үгсийг сур.
- Дараагийн долоо хоногийн хичээлийг урьдчилж бэлд.
- Ангид хэрэглэж буй дүрмийг давтахдаа (номын ар талд буй) дүрмийн хавсралт хэсгийг ашигла.

Англи хэл сурах миний төлөвлөгөө

EnglishConnect курсууд нь англи хэлийг долоо хоног бүр 10-аас дээш цаг давтахад танд туслах ба өөрийн давтсан цагийг бүртгэж хөтлөх төлөвлөгөөтэй ирдэг. Давтахад зарцуулсан цагаа бүртгэж, ахицаа тэмдэглэхдээ энэ төлөвлөгөөг ашигла. Англи хэл сурах миний төлөвлөгөө танд давтаж суралцах хэд хэдэн аргыг санал болгодог.

- Долоо хоног бүрийн хичээлдээ ирж, англи хэлний яриаг сонсож, дадлага хий.
- EnglishConnect хичээл бүрийн төгсгөлд байгаа Үйлдэх урилгыг бөглөж хий. Энэ нь танд ангид сурсан зүйлээ амьдралд хэрэглэх боломжийг өгнө.
- Хичээл бүрийн үгсийг давтаж, яриандаа ашигла. Үгсийг бичиж ав мөн хэлж хэрэглэ.

- Гарын авлагын ард байдаг гэрийн даалгаврын үгсийг хэрэглэ. Гэрийн даалгаврын үгс нь хичээлийн үгсийн задаргаа юм.
- Хамтрагчтайгаа эсвэл бие даан хичээлийн харилцан яриаг давт.
- Дараагийн хичээлийн үгсийг урьдчилж үз. Энэ нь таныг суралцах зүйлд тань бэлтгэх болно.
- Duolingo бол Android болон Apple-ийн хэрэглэгчдэд зориулсан үнэгүй онлайн эх сурвалж юм. Дараах app store-ууд руу ор. Duolingo нь гар утасны дата ашигладаг тул та зөөврийн төхөөрөмжөөрөө WiFi-д холбогдсон үедээ үүнийг ашиглаж болох юм. Duolingo-г duolingo.com-оос үнэгүй ашиглах боломжтой. Өдөрт 10-15 минут Duolingo-ийн тусламжтайгаар дадлага хийхийг танд санал болгож байна.
- Ярилцах хамтрагч хөтөлбөрт оролцох нь танд долоо хоног бүр төрөлх англи хэлтэй хүнтэй Skype юмуу Facetime-аар видео ярилцлага хийх боломж олгодог.
- Англи хэлний бусад дадлага хийх үйл ажиллагаанд англи хэлээр кино, зурагт эсвэл нэвтрүүлэг үзэх, англи хэл дээрх радио, бусад аудио сонсох зэрэг нь ордог. Мөн ангийнхантайгаа болон бусад хүнтэй англиар ярьж дадлага хийнэ.

Миний суурь

Олон газарт Миний суурь нь EnglishConnect англи хэлний хичээлүүдтэй хамт заагддаг анги юм. Миний суурь нь хувь хүмүүсийг сүнслэг болон материаллаг байдлын хувьд бие даах чадвартай болоход хөтөлдөг зарчмуудыг сурч мэдэж, дагаж

амьдрахад тусалдаг. Энэ 20 минутын ангийг Миний суурь гарын авлагаас зарчим сонгон ярилцлага өрнүүлэхэд ангийн гишүүдийг томилдог ангийн ерөнхийлөгч ихэвчлэн хөтөлж явуулдаг.

ТА ХЭЗЭЭ, ХААНА, ХЭРХЭН СУРАЛЦАХ ВЭ?

Суралцах зөвлөгөө

- Суралцах хэвшилд тань хамгийн сайн тохирох газрыг сонго.
- Англи хэл сурах, давтах өдрийн тодорхой цагийг сонго.
- Ангиас гадуур дадлага хийхээр төрөлх англи хэлтэй эсвэл англи хэл сурч байгаа хэн нэгэн хүнийг ол.
- Ангид болон ангиас гадуур аль болох англиар их ярь. Хэрэв та ямар нэг зүйлийг англиар хэлж мэдэхгүй байвал мэддэг үгсээ ашиглан дүрслэхийг хичээ.
- Сурсан шинэ үгсийн жагсаалт гарга. Жижиг картууд болон үгсийн сангийн дэвтрээ ашиглан энэ жагсаалтыг байнга давт.
- Хэрэв та интернэтэд холбогдсон бол долоо хоног бүрийн онлайнээр сонсох хичээлийн видео бичлэгийг үзэж болно.

Шинэ хэл сурах нь цаг хугацаа, тэвчээр, уйгагүй байдлыг шаарддаг үйл явц юм. Энэ нь мөн хөгжилтэй, зугаатай байж болно. EnglishConnect-оор дамжуулан англи хэлийг сурч, хэрэглэх шийдвэр гаргасан танд баяр хүргэе.

MY ENGLISH PRACTICE PLAN

WEEK	ATTEND CLASS	COMPLETE THE INVITATION TO ACT	REVIEW VOCABULARY FROM LAST CLASS	PRACTICE HOMEWORK VOCABULARY	PRACTICE CONVERSATION FROM LAST CLASS
Example	1 hour	.5 hours	1 hour	1 hour	.5 hours

PREVIEW VOCABULARY FOR NEXT CLASS	DUOLINGO	SPEAKING PARTNERS	OTHER ENGLISH PRACTICE	TOTAL HOURS SPENT LEARNING ENGLISH
<i>.5 hours</i>	<i>2 hours</i>	<i>1 hour</i>	<i>3 hours</i>	<i>10.5 hours</i>

1-Р ХИЧЭЭЛ: ТАНИЛЦУУЛГА ХИЧЭЭЛ

Би яагаад англи хэл сурч байгаа вэ?

ENGLISHCONNECT-ЫН ТАНИЛЦУУЛГА

Зорилго

1. EnglishConnect курс англи хэл сурахад минь хэрхэн тусалж болохыг би мэдэж авах болно.
2. Би Англи хэл сурах миний төлөвлөгөөг хэрхэн ашиглахыг сурна.
3. Би ангид тавих хүсэлтэд хариулж сурна.
4. Би ангид хүсэлт гаргахад суралцана.

Яагаад та англи хэл сурч байгаа вэ?

1. Та танилцуулга хуудсан дээр англи хэл сурч байгаа шалтгаанаа бичсэний дараа, хамтрагчдаа яагаад англи хэл сурахыг хүсэж байгаа талаараа тайлбарла. Та үүнийг төрөлх хэлээрээ тайлбарлаж болно.
2. Та англи хэлний энэ курст хамрагдсанаар ямар зорилгод хүрэхээр хичээж буй тодорхой зорилго бич. Жишээ нь, "Би долоо хоног бүр 20 шинэ үг сурна." Та үүнийг төрөлх хэлээрээ бичиж болно.

Зорилго:

Та юу судлах вэ?

EnglishConnect 2 суралцагчийн гарын авлага болон танилцуулга доторх Англи хэл сурах миний төлөвлөгөөний талаар уншаад, viii болон ix хуудсан дахь Англи хэл сурах миний төлөвлөгөө хүснэгтийг үз. Хэрэв та Англи хэл сурах миний төлөвлөгөөний аль нэг хэсгийг ойлгохгүй байвал асуугаарай. Та үүнийг төрөлх хэлээрээ гүйцэтгэж болно.

Та хаана, хэзээ, хэрхэн суралцах вэ?

Та **хаана, хэзээ, хэрхэн** хамгийн сайн суралцдаг тухай бод. Бодож байгаа зүйлээ бич. Хамтрагчтайгаа санаа бодлоо хуваалц. Та санаа бодлоо төрөлх хэлээрээ хуваалцаж болно.

Хаана: _____

Хэзээ: _____

Хэрхэн: _____

WARM-UP

Target Phrases

Please Could you spell that, please?
Thank you Could you repeat that, please?

Vocabulary

Nouns

desk computer
chair screen
board

Verbs

look at _____ repeat quiet down practice
listen to _____ sit down pay attention say
return to _____ stand up focus write

LESSON CONVERSATION AND ACTIVITY

Conversation

A = Instructor, B = Learner

A: Please quiet down and return to your seat.

B: OK.

A: Look at page 1 in your book. Listen to the sentence and then repeat: "I'm from Germany."

B: I'm from Germany.

Activity

Give commands to a partner.

A: Please pay attention and look at the board.

B: OK. (partner looks at the board)

WRAP-UP

Summary

Now I can . . .

- 1. say how the EnglishConnect course can help me learn English.
- 2. tell someone how to use My English Practice Plan.
- 3. respond to classroom requests.
- 4. make classroom requests.

Now I know . . .

Invitation to Act

Review and fill out My English Practice Plan this week. Make flash cards with the vocabulary words you don't know and practice them.